

Төслийн мэдээлэл 2013 оны 8 дугаар сар, №7

“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл” дуусгавар болно

Монгол Улсын Боловсрол соёл шинжлэх ухааны яам, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд 2010 оны 4-р сараас эхлэн хэрэгжүүлсэн “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл” 2013 оны 8-р сарын эцэст дуусгавар болохоор боллоо. 3 жил хагасын хугацаанд хамтран зүтгэсэн, туслалцаа үзүүлсэн бүх хүнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Энэхүү төсөл нь “Хүүхдийн хөгжлийг дэмжих багшлахуйн арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” зорилгоор хэрэгжсэн билээ. Төслийн эцсийн бүтээгдэхүүн болон гол үр дүнг доор танилцуулъя.

- Мэргэжлийн баг бүрдүүлэв.
- Сургалтын модуль боловсруулав.

Сургалтын модулийн нэр	Тайлбар
Хичээлийн судалгааны арга зүйн үндэс	Хичээлийн судалгааны үндсэн ухагдахуун болон зохион байгуулах аргын талаар нэгтгэн дүгнэв.
Багшид зориулсан модуль	Физик, Хими, Хүн орчин, Хүн байгаль, Математик /бага/, Математик /суурь/, Мэдээлэл зүй, Төсөлт ажил хичээлүүдийн багшлахуйн арга зүйн шинэчлэлийг дэмжихэд зориулав.
Хичээлийн судалгаанд удирдлагын үүрэг оролцоо	Боловсролын газрууд болон сургуулийн удирдлагын зүгээс хичээлийн судалгааны хэрэгжилтийг дэмжихэд зориулав.
Багш бэлтгэдэг их дээд сургуулиудын сургалтад зориулсан хичээлийн хөтөлбөр	Багш бэлтгэх их дээд сургуульд хичээлийн судалгааны тухай хичээл нэмж оруулахад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн.
Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежментийн гарын авлага	Суралцахуйд суурилсан багшлах арга зүйн хэрэгцээ шаардлага нэмэгдэж байгаагийн зэрэгцээ, энэ төслийг хэрэгжүүлснээр буй болсон менежментийн туршлагыг танилцуулав.

- Загвар аймаг, дүүрэгт (СХД болон Булган, Завхан аймаг) “Аймаг, дүүргийн баг”-ийг бэлтгэв.
- Загвар сургуулиудад хичээлийн судалгаа зохион байгуулж, мониторинг хийв.
- Бүх аймаг, дүүрэгт “Аймаг, дүүргийн баг”-ийг бэлтгэв.
- Хичээлийн судалгааны видео бүтээв.
- Хичээлийн судалгааны вебсайт гаргав.
<http://hicheelin-sudalгаа.mn/>
- Загвар бус аймаг, дүүрэгт зориулсан сургалт болон мониторинг зохион байгуулав.

Төслийн хүрээнд хэрэгжүүлж ирсэн эдгээр үйл ажиллагааг БМДИ үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусган, арга хэлбэрийг нь өөрчлөн цаашид ч үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.



Булган аймаг дахь судалгаат хичээлүүд



Төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн уулзалт зохион байгуулав

2013 оны 7-р сарын 5-6-нд БШУЯ, Боловсролын хүрээлэн, БМДИ, Нийслэлийн боловсролын газрын холбогдох хүмүүс нэг дор цуглан, төсөл дууссанаас хойш 3 жилийн дараа бага, дунд боловсролын дүр дураг ямархуу байхыг тодруулан ярилцаж, БМДИ зэрэг холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны график төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн уулзалтыг зохион байгууллаа.

Уг ажлын хэсгийн уулзалтаар оролцогчид, мэргэжлийн баг болон төслийн хүрээнд бэлтгэгдсэн орон нутгийн сургагч багш нар, сургалтын модулийг хэрхэн ашиглах талаар санал бодлоо солилцсон бөгөөд уулзалтын үр дүнг БМДИ-ийн тал эцэслэн дүгнэх юм. Түүнчлэн, уулзалтын агуулгыг нэгтгэн холбогдох бүх байгууллагуудад хандсан зөвлөмж болгон гаргахаар төлөвлөсөн.

Уулзалтын хаалтын үеэр сургалтын модулиудыг (Хичээлийн судалгааны арга зүйн үндэс, Багшид зориулсан модуль /8 судлагдахуун/, Хичээлийн судалгаанд удирдлагын үүрэг оролцоо, Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежментийн гарын авлага тус бүрээс 700 хувь, Багш бэлтгэдэг их дээд сургуулиудын сургалтад зориулсан хичээлийн хөтөлбөрөөс 50 хувь) төслийн багаас БМДИ-д хүлээлгэн өглөө.

Боловсруулсан сургалтын модулиуд



Гарчиг:	
“Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл” дуусгавар болно	1
Төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн уулзалт зохион байгуулав	1
Загвар аймагт хичээлийн судалгааны мониторинг хийлээ	2
Хичээлийн судалгааны семинар зохион байгуулав	2
Японд сургалт зохион байгуулав	3
Байгалийн ухаан, бага ангийн Математикийн хичээлийн хэлэлцүүлэг сургалт зохион байгуулав	4
“Хичээлийн судалгааны эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал” зохион байгуулагдана	4
Сурталчилгааны үйл ажиллагааны тайлан	4
“Японы Байгалийн ухааны боловсролын эрдэм шинжилгээний бага хурал”-д оролцоно	4
ЖАЙКА-ийн төслийн багаас	4

Загвар аймагт хичээлийн судалгааны мониторинг хийлээ

2013 оны 3-4 сард төслийн загвар аймаг, дүүрэгт хичээлийн судалгааны 5 дахь удаагийн мониторингийг зохион байгууллаа. Энд, та бүхэнд хэрэг болохуйц жишээ, цаашид анхаарах зүйлүүдийг танилцуулъя.

Хичээлийн судалгааны менежментийн талаар

- Зарим сургуульд долоо хоногийн аль нэг өдрийг “Хичээлийн судалгааны өдөр”-өөр сонгон, долоо хоног бүр сургалтын менежер нь лекц уншин, багш нар нь хичээлийн бэлтгэл судалгаа хийж байна.
- Нилээд олон сургуулиудад 2011, 2012 оны Япон дахь сургалтад хамрагдсан багш нар голлох үүрэгтэй оролцож, самбар төлөвлөлт болон дэвтэр хөтлөлтийг сэдвээр сонгон сургуульд суурилсан хичээлийн судалгааг зохион байгуулж байна.
- Тухайн судалгаат хичээлийн бэлтгэлд оролцоогүй багш хөндлөнгийн ажиглагчаар хичээл болон хэлэлцүүлэгт оролцож, хэлэлцүүлэгт шинэлэг санал зөвлөмж өгч байна.
- Зэргэлдээх сургуулиудын багш нартай хамтран судалгаат хичээл зохион байгуулж буй сургууль ч байсан. Өөрийнх нь сургуульд ижил мэргэжлийн багш цөөн байдаг бол бусад сургуулийн багш нартай хамтран ажиллах байдлаар хичээлийн бэлтгэл судалгааг үр дүнтэй хийх боломжтой.
- Хэлэлцүүлгийн хөтлөгч, хичээл заасан багш, ажиглагч багш нар дэс дараалан санал хэлэх гэсэн хэв загварт хатуу баригдалгүй, анхаарвал зохих зүйлүүдийг бичсэн ажиглалтын тэмдэглэлийнхээ дагуу зохион байгуулж буй хэлэлцүүлэг ч ач холбогдолтой байв.

Хичээлийн талаар


- Малын ашиг шим сэдвээр зохион байгуулсан судалгаат хичээлд эцэг эхийн төлөөлөл зочноор оролцож, үндэсний хувцас оёх зэрэг уламжлалт технологийг хүүхдүүдэд танилцуулсан.
- Энерги сэдэвт физикийн хичээл дээр хүүхдүүд таамаглал дэвшүүлэн, түүнийг батлах туршилт хийв. Туршилтын хэрэглэгдэхүүн болгож, таазнаас утсаар дүүжилсэн хуванцар сав, цахилгаан утасны даруулга зэрэг гарын доорх материал ашиглажээ.

Цаашид анхаарах зүйл

- Хэд хэдэн судалгаат хичээл дээр оньсого таавар ашиглах зэргээр хичээлийн гол сэдэвтэй холбоогүй сэдэлжүүлэлт хийгдэж байсан. Хичээлийн сэдэлжүүлэлт нь хичээлийн агуулгыг бодуулахад дөхөм болохуйц байх ёстой.
- Туршилттай хичээл дээр хүүхдүүд зөвхөн удирдамжийн дагуу л ажиллаад байсан. Хамгийн чухал нь хүүхдэд юуны тулд, юуг хэрхэн судлах гээд байгааг нь ойлгуулах явдал юм. Хүүхдүүдээр таамаглал дэвшүүлүүлэх, туршилтынхаа үр дүнгийн талаар бодох хангалттай хугацаа өгөх хэрэгтэй.
- Хүүхдүүдийн хэдийнэ мэддэг зүйлийг нь хийлгээд байснаас бус, шинэ мэдлэг бүтээлгээгүй хичээл ч харагдаж байлаа. Хүүхдийн өмнөх мэдлэгийг тодорхойлон, хөтөлбөртөө “Ямар байсан хүүхэд /одоо/”-ийг “Ямар хүүхэд болгох гээд байгаа вэ” гэдгээ тодорхой тусгах шаардлагатай.
- Хүүхдүүдийнхээ байдлыг зүгээр л ажиглаад суух юм бол хэрхэн сурч буйг нь мэдэх аргагүй. Хүүхдүүдээр сурсан зүйлийнх нь тухай сэтгэгдлийг нь /Ойлгож мэдсэн зүйл, эргэлзээтэй санагдсан зүйл, өөрийн бодлыг бусад хүүхдүүдийнхтэй харьцуулж үзээд бодсон зүйл г.м/ бичүүлэх явдал ч бас л нэг арга юм. Өдөр тутам хүүхэд нэг бүр дээр анзаарсан зүйлээ суудлын хуваарьт тэмдэглэх арга ч үр дүнтэй байдаг.



2 дугуй дүрсийг эвлүүлэн янз бүрийн өнцөг гаргаж үзэв. (дээд талын зураг: СХД)
Заасан цэгүүдийг координатын хавтгай дээр олж, таван хошуу бүтээв. (доод талын зураг: Завхан)



Хичээлийн судалгааны семинар зохион байгуулав

2013 оны 5 сарын 1-3-нд БШУЯ-ны 4 мэргэжилтэн, Боловсролын хүрээлэнгийн 10 судлаач болон БМДИ-ийн 21 арга зүйчид зориулсан Хичээлийн судалгааны семинарыг зохион байгууллаа. Энэхүү семинарыг “Тус төсөлд ашигласан хичээл ажиглалтын хуудсыг цаашид өргөнөөр ашиглах нь зүйтэй” гэсэн 2012 оны 9 сард хэрэгжсэн төслийн эцсийн шатны үнэлгээний багаас өгсөн зөвлөмжид үндэслэн зохион байгуулсан болно.

Семинарын үеэр, төслийн эхний шатны загвар сургуулиар ажилласан 45-р сургуулийн хамт олон өөрсдийн туршлага сургамж болон судалгаат хичээлтэй холбоотой нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр, хичээлийн бэлтгэл судалгаагаа хэрхэн хийсэн тухайгаа танилцуулав. Мөн, ажиглалтын хуудас ашиглан хичээл ажиглах үүргээ тодорхой болгосны дараа судалгаат хичээлд ажиглалт хийн, хичээлийн дараахи хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Семинарын сүүлийн өдөр, сургагч багш хичээлийн судалгааны талаар лекц уншиж, оролцогчид өмнөх өдрийнхөө судалгаат

хичээлийн хөтөлбөрийг сайжруулах дадлага ажил хийсэн. Эцэст нь сургалтын модуль зэрэг төслийн эцсийн бүтээгдэхүүнийг цаашид хэрхэн ашиглах тухай харилцан ярилцсанаар энэ удаагийн семинарын үйл ажиллагааг өндөрлүүлсэн юм. Энэ удаагийн семинараар дамжуулан оролцогчид хичээлийн судалгааны талаархи хандлага, сонирхлоо улам бүр дээшлүүлж чадсан юм.

Монгол Улсад хичээлийн судалгааны тухай анх 2006 онд танилцуулж байсан бөгөөд багшид зориулсан зөвлөмж боловсруулах зорилгоор хийж эхэлсэн хичээлийн судалгааг төслийн хоёр дахь шатанд багшлахуйн арга зүйн шинэчлэлийн арга хэрэгсэл болгон ашиглах болсон билээ. 6 жилийн үйл ажиллагааны үр дүнг 1 өдөр хагасын хугацаанд сурч өөрийн болгоно гэдэг боломжгүй зүйл. Мөн, арга зүйн шинэчлэлд “Бүрэн төгс болох” гэсэн ойлголт байдаггүй. Цаашид БШУЯ, Боловсролын хүрээлэн, БМДИ-ийн мэргэжилтэн, судлаач, арга зүйчид та бүхэн өөрсдийн судалгаа шинжилгээгээ тасралтгүй үргэлжлүүлэн, ЕБС-ийн багш нартай хамтаар суралцахыг хүсье.

2013 оны 5-6 сард Япон дахь сургалтыг зохион байгуулсан бөгөөд энэ жил БШУЯ, Боловсролын хүрээлэнгийн төлөөлөл 10 оролцогчдод Японы боловсролын тогтолцооны талаар ойлголт мэдлэг өгөх зорилго бүхий “Боловсролын тогтолцооны сургалт”, БМДИ-ийн төлөөлөл 10 оролцогчдод Японы багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцооны талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх зорилго бүхий “Багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцооны сургалт”-ыг тус бүр зохион байгуулсан юм.

“Боловсролын тогтолцооны сургалт”-ын оролцогчид Үндэсний боловсролын бодлогын хүрээлэн, Токио Гакүгэй их сургууль, Сэйшин Жоши их сургууль дээр Японы боловсролын танилцуулга болон боловсролын стандарт, багш бэлтгэх тогтолцоо, нийгмийн ухааны боловсрол, боловсролын үнэлгээний тухай лекц сонссоноос гадна Японы БШУЯ, Сурах бичгийн судалгааны төв, сурах бичиг хэвлэлийн Кэйринкан ХК, Инаги хотын Инаги 2-р бага сургууль, Нэрима дүүргийн Оизүми 2-р дунд сургууль, мөн дүүргийн Хикаригаока 1-р дунд сургууль, Сайтама их сургуулийн боловсролын факультетийн харьяа дунд сургууль, Токио хотын Хигаши Ямато ахлах сургуульд тус тус зочилсон.

“Багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцооны сургалт”-ын оролцогчид Японы багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоо, арга зүйчийн чиг үүрэг, судлагдахууны боловсролыг дэмжих үйл ажиллагаа, сургуулийн төлөвлөгөө, хичээлийн судалгаа болон хичээлийн бэлтгэл судалгааны тухай лекц сонсож, Сэтагаяа дүүргийн Сакүрагаока бага сургууль, Нэрима дүүргийн Кайшин 1-р дунд сургуульд зочилсон. Уг сургалтын агуулгын зарим хэсгээс толилуулъя.

Энэхүү сургалтын оролцогчид нь багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах мэргэжлийн байгууллага болохын хувьд дараах 2 байгууллагаар зочилсон.

- **Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын төв:** Японы БШУЯ-тай нягт уялдаатай ажиллан сургуулийн захирал, багш нарт зориулан сургалт зохион байгуулж, бүс нутгийн удирдах ажилтан болон сургалтын чиглүүлэгчдийг бэлтгэдэг. Мөн, бүх хот мужийн Боловсролын хороонд сургалтын талаар чиглүүлэг зөвлөмж өгөх, дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.
- **Токио хотын Багш, ажилтны сургалтын төв:** Японы бүх мужуудад тухайн мужийнхаа багш, ажилтнуудад зориулан сургалт зохион байгуулах чиг үүрэг бүхий сургалтын төвүүд үйл ажиллагаа явуулдаг. Токио хотын Багш, ажилтны сургалтын төв нь Токио хотын сургуулиудын багш, ажилтнуудад зориулан хуулиар тогтоосон эхний жилийн үндсэн сургалт, 10 дахь жилийн үндсэн сургалтуудыг зохион байгуулахаас гадна Токио хотын “Залуу багш нарыг 3 жилийн хугацаанд бэлтгэх” зорилтыг биелүүлэх зорилгоор 2 дахь жилийн болон 3 дахь жилийн сургалтуудыг тус тус зохион байгуулж байна.

Боловсролын суурь хууль болон Боловсролын төрийн албан хаагчийн тусгай хуульд “Багш цаг ямагт судлаач байж, өөрийгөө хөгжүүлэхэд чармайлт гарган ажиллах хэрэгтэй” гэж заасан байдаг. Мөн, нийгмийн өөрчлөлттэй уялдан багшид тавигдах шаардлага, ур чадвар, хүүхэд сурагч, эцэг эхчүүдийн хэрэгцээ шаардлага улам бүр хүрээгээ тэлж байна. Японд зөвхөн төрийн байгууллага багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг явуулах бус, сургууль багш бүр энэхүү үүргийг хүлээх ёстой гэж үздэг.

Энэ удаагийн сургалтаар сургуулиуд дахь “Тасралтгүй судалгаа шинжилгээ, өөрийгөө хөгжүүлэх” ажлын жишээ болгон Сайтама их сургуулийн боловсролын

Энэ хичээл дээр бодох бодлого

факультетийн харьяа дунд сургуулийн судалгааны зөвлөгөөнтэй танилцаж, сургууль болон судлагдахуунд суурилсан хичээлийн судалгааны тухай лекц сонссон.


Оролцогчдын Японы багш нарын заах арга зүйн талаарх ойлголтыг нь гүнзгийрүүлэх зорилгоор байгалийн ухаан, бага ангийн математикийн хичээлтэй танилцуулсан.

- Байгалийн ухаан: Сагамихара хотын Чюүо дунд сургуулийн 2-р ангид Шимизү Рёоичи багшийн заасан хичээл

“Хий үүсэх химийн урвалын өмнө буюу хойно масс өөрчлөгдөхгүй болох”-ыг туршилтын үр дүнд тулгуурлан бодуулах зорилготой хичээл байв. Сэдэлжүүлэлтийн хэсэгт өмнөх хичээлийг эргэн сануулсан ба тухайн цаг дээр туршилт хийх тухай тайлбарласан. Дараа нь багш туршилтын хэрэглэгдэхүүнийг танилцуулан, туршилт хийх аргачлал, аюулгүй ажиллагааны талаар удирдамж өгөв. Туршилтын дараа, сурагчид хоорондоо ярилцан, үр дүнгээ хэлэлцэх цаг гаргаж өгсөн байлаа. Мөн, амжилтгүй болсон туршилтын үр дүнгийн талаар анги нийтээрээ ярилцаж, яагаад ийм үр дүн гарсан тухай бүгд эргэцүүлэн бодсон.

- Бага ангийн математик: Токио Гакүгэй их сургуулийн харьяа Коганэй бага сургуулийн 4-р ангид Аояма Шёожи багшийн заасан хичээл

“4 порц ширүко бэлтгэхэд 8 ширхэг мочи ашиглажээ. Үүний адил ширүко ... порц бэлтгэхэд хэдэн ширхэг мочи хэрэгтэй вэ?” гэсэн бодлого бодох хичээл байв. Хүүхэд бүр тоон шулуун ашиглан хариултыг олох аргыг бодож олон, түүнийгээ дэвтэртээ тэмдэглэж байсан. Хичээлийн сүүлийн хагаст хэд хэдэн хүүхэд бодолт хийсэн цаасаа самбарт хадан, бодолтуудаа тайлбарласан. Багш хүүхдүүдийн тайлбарыг бусад хүүхдүүдээр нэмж тайлбарлуулах, мөн бодсон аргыг хэрхэн ойлгож буйг нь өөр хүүхдээр тайлбарлуулах зэргээр хүүхдүүдийн бодлыг дэмжиж, бодлоо нийт хүүхдүүдтэй хуваалцах боломжийг илүү олгосон хичээл болсон.



Хүүхдийн хариулт: Самбарт хүүхдүүдийн хариултыг бичих байдлаар хичээлийн явцыг илтгэнэ.

Хүүхдүүдийн нэртэй самбарын соронз: Хариултын хажууд хариулсан хүүхдийн нэртэй самбарын соронзыг тогтооно. Цагаан шохойгоор тэмдэглэсэн нь эхний хариулт, шар шохойгоор тэмдэглэсэн нь 2 дахь хариулт

Сурталчилгааны үйл ажиллагааны тайлан

Төслийн хүрээнд өнөөг хүртэл “Төслийн мэдээлэл” хэвлүүлэх, цахим хуудсанд нийтлэл оруулах зэргээр сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулж ирлээ.

Хичээлд шаардлагатай материал сэлт хязгаарлагдмал байдаг ч, бага ч атугай та бүхэнд тус дэм болохуйц мэдээлэл өгөх зорилгоор “Багш” сонинд 7 удаагийн нийтлэлээр загвар сургуулиудад зохион байгуулагдсан судалгаат хичээлийн жишээг танилцуулсан билээ.

№.	Судлагдахуун: Хичээлийн сэдэв
211	Хими: 1-р бүлгийн элементийн устай харилцан үйлчлэх урвал
212	Дунд ангийн Математик: Параллелограммын талбайн томъёо гаргах
213	Бага ангийн Математик: Сая хүртэлх тоо
214	Хүн байгаль: Өдөр шөнө яагаад болдог вэ
215	Физик: Бодисын дулаан
216	Төсөлт ажил: Малын ашиг шим
217	Хүн орчин: Монгол орны дархан цаазат амьтан Мэдээлэл зүй: Үүрэн холбооны технологи

Төсөл дууссаны дараа ч дараах цахим хуудсаар дамжуулан үргэлжлүүлэн мэдээлэл хүргэхээр төлөвлөсөн. Энд мөн хичээлийн жишээ ч танилцуулдаг тул та бүхэн уг цахим хуудсыг судлаад үзээрэй.

<http://hicheeliin-sudalгаа.mn/>

“Японы Байгалийн ухааны боловсролын эрдэм шинжилгээний бага хурал”-д оролцоно

2013 оны 8-р сарын 10-11-ний өдрүүдэд Япон Улсын Хоккайдо мужид “Японы Байгалийн ухааны боловсролын 63 дахь удаагийн үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний бага хурал” зохион байгуулагдах юм. Энэ арга хэмжээн дээр багш нар байгалийн ухааны боловсролын чиглэлээр өдөр тутам хийдэг судалгааныхаа үр дүнгээс танилцуулдаг байна.

Хуралд оролцох саналыг төслийн мэргэжлийн багаас асуусны эцэст Физик, Хүн орчин багуудаас нийт 3 гишүүн харъяа байгууллагынхаа зардлаар Японд очиж, уг хуралд оролцон илтгэл тавих болсон.

Байгалийн ухаан, бага ангийн Математикийн хичээлийн хэлэлцүүлэг сургалт зохион байгуулав

Японы багш нар өөрсдийн хичээлийн судалгааны үр дүнг хуваалцах, шинээр хичээлийн материал боловсруулах, арга зүйгээ судлах зорилгоор сайн дурын үндсэн дээр янз бүрийн дугуйлан ажиллуулдаг. Ийм үйл ажиллагааг Монгол Улсад ч дэлгэрүүлэхийн тулд хэлэлцүүлэг сургалтыг тогтмол зохион байгуулж ирлээ.

Байгалийн ухааны хэлэлцүүлэг сургалт

Энэ оны 5-р сард МУИС-ийн ФЭС дээр багш, оюутнуудад зориулсан хэлэлцүүлэг сургалт зохион байгуулав.

Математикийн хэлэлцүүлэг сургалт /бага/

“Төслийн мэдээлэл №6”-д танилцуулсан эхний хэлэлцүүлэг сургалтаас хойш 2013 оны 6-р сарыг дуустал Японы залуу сайн дурын гишүүнтэй хамтран сар бүр 1 удаа, нийт 5 удаагийн хэлэлцүүлэг сургалтыг

зохион байгууллаа. Хэлэлцүүлэг сургалтын сэдвийг хүснэгтэд сийрүүлэв.

Сар	Сэдэв
1-2-р сар	Бутархайны тооны нэмэх хасах үйлдэл ба Трапецийн талбайг олох
3-р сар	Үржүүлэх үйлдлийн заах аргыг харьцуулах
4-р сар	2 оронтой тоог 1 оронтой тоогоор үржүүлэх ба бүтэн арвыг 1 оронтой тоогоор үржүүлэх
5-р сар	Огторгуйн дүрсийн гадаргуун талбайг олох
6-р сар	Япон дахь сургалтын үр дүнг хуваалцах нь ба Хичээлийн материал (Кёозай) сонгох арга

Дэлгэрэнгүй зүйлийн талаар цахим хуудаснаас сонирхох боломжтой.

6 дахь удаагийн хэлэлцүүлгийг 1-р улирлын амралтаар (Нийслэлийн 1-р сургуульд), 7 дахь удаагийн хэлэлцүүлгийг 2-р улирлын амралтаар (Нийслэлийн 5-р сургуульд) тус тус зохион байгуулахаар төлөвлөсөн.

“Хичээлийн судалгааны эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал” зохион байгуулагдана

2013 оны 8-р сарын 15-16-ны өдрүүдэд, Багшийн хөгжлийн төв дээр “Хүүхдийн хөгжил - Хичээлийн судалгаа сэдэвт хичээлийн судалгааны эрдэм шинжилгээний анхдугаар бага хурал”-ыг зохион байгуулна. Уг хурлын зорилго нь төслийн загвар болон загвар бус аймаг, дүүрэг, мэргэжлийн багийн гишүүд туршлага солилцон, Монгол Улсад хичээлийн судалгааг улам бүр хэвшүүлэн хөгжүүлэх суурийг тавих явдал юм. Аман илтгэлд сургуульд суурилсан хичээлийн судалгаа ба төслийн зорилтот 8 судлагдахууны судалгаат хичээлийн 33 жишээг танилцуулахаас гадна ханын илтгэлүүд ч тавигдах болно.

Хурлын төгсгөлд, цаашид хичээлийн судалгааг хөгжүүлэх зорилгоор ТББ-ыг үүсгэн байгуулах болсон тухай зарлахаар төлөвлөсөн.

ЖАЙКА-ийн төслийн багаас

Энэхүү төсөл нь сургалтын модуль боловсруулах, сургалтын сургагч багш бэлтгэх зэрэг үйл ажиллагааг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлж ирлээ. Төсөл дуусах дөхсөнтэй холбогдуулан, зөвхөн багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулснаар үндэсний хэмжээнд багшлахуйн арга зүйн шинэчлэлийг хэвшүүлэх нь хүндрэлтэй гэдгийг Монголын талын холбогдох хүмүүс ойлгон хүлээн зөвшөөрөх болжээ. Эдүгээ багшийн ажиллах болон хүүхдийн суралцах орчин нөхцөл, сурах бичгийн шинэчлэл, хэрэг болохуйц хичээлийн хэрэглэгдэхүүн боловсруулалт зэрэг олон тулгамдсан асуудлууд байсаар байна. Төслийн хүрээнд буй болгон хөгжүүлж ирсэн мэдлэг, хүний нөөцийн сүлжээ нь эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулна гэж үзэхийн хамт, цаашид Монголын багш нар улам бүр хичээл зүтгэл гарган ажиллана гэдэгт итгэж байна.

Дашрамд та бүхэн төслийн цахим хуудсыг хойшид ч үзэх боломжтой юм.

<http://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/004/index.html> (Монгол хэлээр)

2013 оны 9-р сараас хойш тодруулах зүйл баймал, Монголын хичээлийн судалгааны эрдэм шинжилгээний нийгэмлэг, эсвэл ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газарт хандана уу.

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар

Хаяг	Бодь Цамхаг 7-р давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар Төв шуудан 682, Улаанбаатар 211213
Утас	+976-11-325939